АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахир сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2023/11-НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Н.Алтантуяа<br>Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023-03-24 № 149

танай ____________-ны № ____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦАХИР СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ГАЛБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогыг сумын төсөвт төвлөрүүлдэг болсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 76.3 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,040,322.0 | 769,490.5 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 491,452.4 | 372,020.4 |
| 33 | АВЛАГА | 207,677.5 | 228,270.4 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 301,900.1 | 135,586.2 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 39,292.0 | 33,613.5 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,126,287.2 | 1,674,994.6 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,126,287.2 | 1,674,994.6 |
| 39200 | Биет хөрөнгө | 3,954,797.5 | 1,441,554.3 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 171,489.7 | 233,440.3 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 5,166,609.2 | 2,444,485.1 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 34,423.6 | 12,600.0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 34,423.6 | 12,600.0 |
| 41300 | Өглөг | 34,423.6 | 12,600.0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,132,185.6 | 2,431,885.1 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,132,185.6 | 2,431,885.1 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,696,645.3 | 446,645.9 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 0.0 | 446,645.9 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,760,691.0 | 1,876,765.1 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 674,849.3 | 108,474.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 5,166,609.2 | 2,444,485.1 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ мянган төгрөгөөр /*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,921,361.8 | 1,352,758.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 188,818.7 | 348,536.5 |
| 110 | Орлогын албан татвар | 47,627.4 | 164,188.9 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 47,627.4 | 164,182.6 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 6.3 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 38,932.6 | 59,251.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 102,258.6 | 125,095.8 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,427,474.4 | 367,655.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,419,527.9 | 367,655.9 |
| 122 | Тусламжийн орлого | 7,946.6 | 0.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,305,068.6 | 636,566.2 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,685,250.9 | 1,256,079.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,685,250.9 | 1,256,079.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,620,757.5 | 952,316.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,590,354.1 | 328,549.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 198,768.0 | 41,475.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 52,568.3 | 99,087.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 92,708.2 | 46,399.1 |
| 2105 | Нормативт зардал | 296,718.3 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,241.8 | 5,434.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,484.4 | 5,071.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,853.3 | 58,030.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 353,061.1 | 368,269.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 64,493.4 | 303,763.1 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,236,110.9 | 96,678.8 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 82,086.8 | 2,773,881.4 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 1,154,024.0 | -2,677,202.6 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 3,330,146.2 | 1,191,568.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 188,818.7 | 348,536.5 |
| 110 | Орлогын албан татвар | 47,627.4 | 164,188.9 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 47,627.4 | 164,182.6 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 6.3 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 38,932.6 | 59,251.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 102,258.6 | 125,095.8 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 6,745.5 | 5,519.7 |
| 1181 | Газрын төлбөр | 12,356.0 | 28,882.3 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 83,157.2 | 90,693.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 197,406.5 | 206,465.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 197,406.5 | 206,465.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,943,921.0 | 636,566.2 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,891,850.3 | 878,127.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,891,850.3 | 878,127.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,169,925.6 | 782,162.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,589,732.0 | 328,549.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 199,223.2 | 41,475.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 57,447.7 | 99,087.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 87,615.7 | 47,214.6 |
| 2105 | Нормативт зардал | 110,829.9 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,679.0 | 5,574.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,384.4 | 5,071.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,766.0 | 144,402.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 82,247.7 | 110,788.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 721,924.8 | 95,964.9 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 438,295.9 | 313,441.2 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 51,912.5 | 267,873.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 51,912.5 | 267,873.2 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 51,912.5 | 267,873.2 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -51,912.5 | -267,873.2 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 0.0 | -165,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 0.0 | 165,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 386,383.4 | -119,432.0 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 105,069.0 | 491,452.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 491,452.4 | 372,020.4 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,978,161.6 | 3,978,161.6 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 10,515.7 | 10,515.7 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,988,677.2 | 3,988,677.2 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -10,515.7 | -10,515.7 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 1,154,024.0 | 1,154,024.0 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,132,185.6 | 5,132,185.6 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 5,132,185.6 | 5,132,185.6 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -23,097.8 | -23,097.8 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,109,087.8 | 5,109,087.8 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -2,677,202.6 | -2,677,202.6 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 2,431,885.1 | 2,431,885.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,541,012.2 | 1,283,569.0 | 257,443.2 | 83.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 932,309.5 | 876,610.8 | 55,698.7 | 94.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 862,459.1 | 806,760.4 | 55,698.7 | 93.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 340,375.2 | 328,549.2 | 11,826.0 | 96.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,546.8 | 41,475.1 | 1,071.7 | 97.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 108,247.2 | 99,087.8 | 9,159.4 | 91.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 48,290.6 | 46,752.2 | 1,538.4 | 96.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,943.4 | 5,574.2 | 3,369.2 | 62.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,100.0 | 5,071.0 | 29.0 | 99.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 160,165.6 | 146,397.7 | 13,767.9 | 91.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 148,790.3 | 133,853.2 | 14,937.1 | 90.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 69,850.4 | 69,850.4 | - | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 69,850.4 | 69,850.4 | - | 100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 335,408.1 | 241,958.2 | 93,449.9 | 72.1 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 273,294.6 | 165,000.0 | 108,294.6 | 60.4 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,541,012.2 | 1,176,636.0 | 364,376.2 | 76.4 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 865,855.8 | 974,170.1 | (108,314.3) | 112.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 675,156.4 | 202,465.9 | 472,690.5 | 30.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 268,988.2 | (268,988.2) | #DIV/0! |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 158,052.5 | (158,052.5) | #DIV/0! |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 8 | 8 | | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 69 | 65 | | 94.2 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 69 | 65 | | 94.2 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 23,428.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 23,428.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,317.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 462.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 854.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 22,111.7 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 22,111.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 23.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,617.1 |
| | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 21,811.7 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт 16,676.3 мянган төгрөгийн зөрчил [1] илэрч зөрчил арилгуулах 2 албан шаардлага хүргүүллээ.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Хоршоо хөгжүүлэх санд 6 зээлдэгчтэй холбоотой 15,296.0 мянган төгрөгийн 2-9 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох,сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ", 11 зүйлийн 11.3-т "Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна." гэсэн заалтыг зөрчиж байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>:*Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

3.1.2 Сумын төсвийн орлогын гүйцэтгэл 3 нэр төрлөөр буюу түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1,036.0 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 183.5 мянга, газрын төлбөр 160.8 мянган төгрөг нийт 1,380.3 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчиж байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>:*Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахир сумын ТТЗ | 2 | 16676.3 | | | 2 | 16676.3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахир сумын ТТЗ | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |